213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		-
<b>13</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	14,741,260,400.00	14,493,725,134.28
<b>1340</b>	<b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	14,584,009,800.00	14,074,313,980.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих		
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	14,584,009,800.00	14,074,313,980.00
134003	Нийгмийн даатгалын сангаас эмнэлгүүдэд олгох санхүүжилт		
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	157,250,600.00	419,411,154.28
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	157,250,600.00	419,411,154.28
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих		
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих		
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		1,195,506,534.82
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		1,464,000.00
<b>6</b>	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>		
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	-	1.00
610001	Төсвийн байгууллага		1.00
610002	Төсвөөс гадуур байгууллага		
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	-	470.00
620001	Удирдах ажилтан		2.00
620002	Гүйцэтгэх ажилтан		376.00
620003	Үйлчлэх ажилтан		92.00
620004	Гэрээт ажилтан		
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	-	<b>470.00</b>
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)		378.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)		92.00
650010	Гэрээт ажилтан		
650011	Улс төрийн албан хаагч (УТ)		

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

байхгүй

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

---

#### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

##### ***Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар***

Баян-Өлгий аймгийн аймгийн Нэгдсэн эмнэлэг нь анхан шатны тусламж, эмчилгээ үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий байгууллага юм.

Аймгийн Нэгдсэн эмнэлгийн зорилгыг “Хүн амд үзүүлэх эмнэлгийн ерөнхий болон төрөлжсөн нарийн мэргэжлийн тусламж үйлчилгээг дэлхийн хөгжилтэй орны түвшинд ойртуулж, орчин үеийн өндөр технологи нэвтрүүлсэн, чадварлаг багаас бүрдсэн оношилгоо, эмчилгээ, сувилгаа, сургалт судалгааны хоёрдогч шатлалын эрүүл мэндийн байгууллага байх” гэж тодорхойлсон байна.

Дээрх зорилгыг биелүүлэхээр дараах зорилтыг дэвшүүлэн ажилласан байна. Үүнд:

1. Хүний нөөцийн хөгжил
2. Үйлчлүүлэгчдэд ээлтэй орчин бүрдүүлэх
3. Цахим орчныг бүрдүүлэх
4. Эмнэлгийн аппарат тоног төхөөрөмжийн хангалт
5. Тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах

#### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

##### ***Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар***

аймгийн Нэгдсэн эмнэлэг нь Эрүүл мэндийн тухай хууль, Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Засгийн газрын 2023 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 241 дүгээр тогтоолоор төрийн албан хаагчдын цалингийн сүлжээнд үнэмлэхгүй хэмжээний өөрчлөлт орсон.

Сангийн сайдын 2023 оны 65 дугаар “Хөтөлбөр батлах тухай” тушаалаар аккруэл суурьт УСНББОУС-ыг нэвтрүүлэх дунд хугацааны хөтөлбөрийг баталсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба нь тус аймгийн төсөвт байгууллагуудын санхүү, бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүрэг бүхий байгууллага юм. Аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2021, 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Аймгийн Нэгдсэн эмнэлэг нь 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

### **Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар**

Аймгийн Нэгдсэн эмнэлгийн даргын 2020 оны 12 дугаар сарын 01-ны өдрийн 212 дугаар тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа мөрддөг байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад *нийцсэн*, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт *тохирсон* байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Аймгийн Нэгдсэн эмнэлэг нь 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1166.5 сая төгрөгөөр буюу 1.04 хувиар өссөн байна.

#### *Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	1,195,506.50	1,464.00	1,194,042.50
Авлага	3,756.20	595,224.30	- 591,468.10
Урьдчилгаа			-
Бараа материал	1,030,803.10	1,249,336.60	- 218,533.50
Үндсэн хөрөнгө	30,041,181.80	31,591,677.70	- 1,550,495.90
<b>Нийт хөрөнгө</b>	<b>32,271,247.60</b>	<b>33,437,702.60</b>	- 1,166,455.00
Өр төлбөр	9,105.60	1,700,928.20	- 1,691,822.60

Аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	32,262,142.00	31,736,774.40	525,367.60
<b><u>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</u></b>	<b>32,271,247.60</b>	<b>33,437,702.60</b>	- 1,166,455.00

Дээрх хүснэгтээс харахад, мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өглөг дансанд өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан байна.

Оны эхэнд байсан мөнгөн хөрөнгийн 1,194.0 сая төгрөгийг үлдэгдлийг тайлант онд зарцуулсан байна.

Оны эцэст эрүүл мэндийн даатгалын санхүүжилтээс 591.5 сая төгрөгийг авлага үүсгэсэн байна.

Бараа материалын үлдэгдэл оны эцэст 218.5 сая төгрөгөөр нэмэгдэж, үндсэн хөрөнгийн үлдэгдэл оны эхнээс 1,550.5 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Богино хугацаат өрийн үлдэгдэл 1,691.8 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Бараа материалын үлдэгдэл 218.5 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Төсвийн хөрөнгөөр 4,082.9 сая төгрөгийн бараа материалыг худалдан авч, 178.3 сая төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй хүлээн авч, 4,041.3 сая төгрөгийн бараа материалыг үйл ажиллагаандаа зарцуулж, 1,315.6 сая төгрөгийн бараа материалыг шилжүүлж, оны эцэст 1,249.3 сая төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй гарсан байна.

Бараа материалын нийт үлдэгдлийн 68.6 хувь буюу 856.6 сая төгрөгийг эм, эм боох материал эзэлж байна.

Эмийн үлдэгдлийн 39.1 хувь буюу 334.9 сая төгрөгийг хугацаа дууссан 3 нэр төрлийн ковидын эм эзэлж байна. Үүнд: Хугацаа дууссан эмийн 297.8 сая төгрөгийг 1ш-ийн үнэ 1,425.0 мянган төгрөг болох 209 ш тоцилизумаб гэсэн эм эзэлж байна.

Үндсэн хөрөнгийн үлдэгдэл 1,550.4 сая төгрөгөөр нэмэгдсэн. Төсвийн хөрөнгөөр 73.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн худалдан авч, бусад эх үүсвэрээр нийт 2,875.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авсан байна. Бүтцийн өөрчлөлтөөр 615.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг шилжүүлэн авсан байна. Тайлант онд аймгийн ИТХ-ын хуралдааны тогтоолоор 2023 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн 198 дугаар тогтоолоор 476.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг, 2023 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн 206 дугаар тогтоолоор 88.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг акталсан байна.

Үндсэн хөрөнгөд 1762.5 сая төгрөгийн элэгдлийг байгуулж, бүтцийн өөрчлөлтөөр шилжиж ирсэн үндсэн хөрөнгийн 249.3 сая төгрөгийн элэгдлийг бүртгэлд тусгаж, акталсан хөрөнгийн 565.4 сая төгрөгийн элэгдлийг данснаас хассан байна.

Аймгийн Засаг даргын 2023 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн А/677 дугаар захирамжаар “Өлгий-Сансар” эмнэлгийг аймгийн Нэгдсэн эмнэлгийн бүтцэд шилжүүлэхээр захирамж гарсан байна.

Аймгийн Засаг даргын 2023 оны 10 сарын 26-ны өдрийн А/698 дугаар захирамжаар “Өлгий-Сансар” эмнэлгийн үндсэн хөрөнгийг хүлээлцэх ажлын хэсгийг байгуулсан байна.

Дээрх шийдвэрийн дагуу аймгийн Нэгдсэн эмнэлэг нь бүтцийн өөрчлөлтөөр нийт 37.3 сая төгрөгийн бараа материалыг, 614.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг хүлээн авсан байна. Хүлээн авсан үндсэн хөрөнгийн элэгдлийг бүртгэлд тусгасан байна.

“Өлгий-Сансар” орон нутгийн өмчит эмнэлгийг аймгийн Нэгдсэн эмнэлгийн бүтцэд шилжүүлэх үед хаалтын балансад ажиллагсад болон байгууллага, хувь хүмүүст өгөх нийт 486.5 сая төгрөгийн өр тусгасныг нэгдсэн эмнэлгийн бүртгэлд тусгаж, нэгтгээгүй байна.

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хуралдааны 2023 оны 10 сарын 16-ны өдрийн 212 дугаар тогтоолын 2-т “Өлгий-Сансар” орон нутгийн өмчит эмнэлгийн халаалт, цахилгаан, нийгмийн даатгалын шимтгэл, татвар, бохир усны төлбөр, эмийн өр болох 250.9 сая төгрөгийг, тэтгэвэр тэтгэмжийн төлбөр болох 188.0 сая төгрөгийг 2024 оны орон нутгийн төсөвт тусгаж батлуулахаар тусгасантай холбоотой өрийг санхүүгийн тайланд нэгтгээгүй байна. /санхүүгийн тайлан болон аймгийн ИТХ-ын тогтоолд тусгагдсан “Өлгий-Сансар” эмнэлгийн өр ялгаатай дүнтэй байгаа тул санхүүгийн тайлан дахь өрийг үнэн зөв дүнтэй гэж үзлээ/

Иймд Нэгдсэн эмнэлгийн удирдлагын зүгээс “Өлгий-Сансар” орон нутгийн өмчит эмнэлгийн өрийн асуудлыг орон нутагт тавьж шийдүүлэх нь зүйтэй.

Тайлант онд аймгийн Нэгдсэн эмнэлгийн өрийн үлдэгдэл 1,691.8 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Үүнд: байгууллагад өгөх өрийн үлдэгдэл 957.2 сая, татварын өглөг 247.1 сая, нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг 202.4 сая, түлш халаалтын өглөг 282.6 сая, үйлдвэрчний эвлэлд өгөх өглөг 11.5 сая төгрөг байна.

Засгийн газрын хувь оролцоо данс тайлант үеийн үр дүнгээр 525.4 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

### **3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг эрүүл мэндийн даатгалын сангаас 14,279.7 сая төгрөгийн, өөрийн орлогоос 152.4 сая төгрөгийн, нийт 14,432.1 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, нийт зарлагыг 14,432.1 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Дээд шатны төсвийн захирагчаас төсвийг хянаж төсвийн төслийн саналаас 1704.6 сая төгрөгөөр нэмэгдүүлэн, 16,138.7 сая төгрөгөөр баталсан байна.

#### **Төсвийн гүйцэтгэл**

Тайлант оны батлагдсан төсөвт тодотгол хийгдсэн байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр эрүүл мэндийн даатгалын санхүүжилт, өөрийн үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос 16,136.8 сая төгрөгийг баталсан байна.

Гүйцэтгэлээр эрүүл мэндийн даатгалын санхүүжилт, өөрийн үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос 14252.2 сая төгрөгийн орлогыг бүрдүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 15446.3 сая төгрөг буюу 95.72 хувьтай байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Эмнэлгийн тусламж үйлчилгээ				
	Хандив тусламж дотоод	14,584.00	13,841.70	742.30	94.91%
	Төсөвт байгууллагын өөрийн орлого /үндсэн/	157.30	410.50	(253.20)	260.97%
	Төсөвт байгууллагын өөрийн орлого /туслах/	200.00		200.00	0.00%
	Харилцах дансны эхний үлдэгдэл	1,195.50	1,194.10	1.40	99.88%
	Дүн	16,136.80	15,446.30	690.50	95.72%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт төсөв аваагүй байна.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Аймгийн Нэгдсэн эмнэлэг нь 2023 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

### 3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Аймгийн Нэгдсэн эмнэлэг нь худалдан авах үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж ажиллаагүй байна. Батлагдсан төсвийн хүрээнд 4,082.8 сая төгрөгийн бараа материал, 73.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

---

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах хууль тогтоомжийн хэрэгжилт, бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор М.Айнур гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Д.Назгүл, дарга, тэргүүлэх аудитор Ж.Айгүл нар тус тус хэрэгжүүлсэн.

Аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 35 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 15,070.1 сая төгрөгөөс 0.5 хувиар буюу 75.3 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 18,792.1 сая төгрөгөөс 0.5 хувиар буюу 93.9 сая төгрөг болж байна.

Аймгийн Нэгдсэн эмнэлгийн нийт орлого, зардалд өмнөх оноос өөрчлөлт орсон байх тул материаллаг байдлыг гүйцэтгэлийн шатанд шинээр тогтоох нь зохимжтой гэж үзлээ.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор хуулийн хэрэгжилтийн хангаж ажилласан байна. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил илрээгүй.

#### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны мэдээллийн хэрэгжилттэй холбоотой зөрчил дутагдал илрээгүй.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2023 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийсэн.Аудитаар уулзалт хийж, байгууллагын талаар мэдээлэл, дотоод аудитын талаар мэдээлэл авч, холбогдох ажлын баримтуудыг цуглуулсан.

Нөлөөллийн мэдүүлгийн баримтыг танилцуулж, гарын үсэг зуруулж, уулзалтын тэмдэглэлийг баримтжуулсан.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд төсөв, мөнгө, хөрөнгөтэй холбоотой тушаал 27 шийдвэрийг байршуулаагүй, түлш шатах тослох материалын 208.9 сая төгрөгийн, сэлбэг хэрэгслийн 25.1 сая төгрөгийн орлого, зарлагын бараа материалын тайланг нярав хөтлөөгүй, бичиг хэргийн зардалд аж ахуйн бараа материалын гүйлгээг бүртгэж ирсэн, 108.4 сая төгрөгийн орлогын, 107.6 сая төгрөгийн зарлагын гүйлгээг бичиг хэргийн зардлын орлого, зарлагад оруулж тайлагнасан, “Бек-толхын” ХХК-аас 9 удаагийн гүйлгээгээр 18.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг шууд гэрээгээр худалдан авахдаа төрийн цахим худалдан авалтыг хэрэгжүүлээгүй зөрчлүүдэд зөвлөмж өгч ажилласан байна.

Аудитын дүнгээр зөвлөмжийг биелүүлж, зөрчлийг арилгаж ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага					
Зөвлөмж	3	493430.0	3	493430.0	100%
<b>Нийт дүн</b>	<b>3</b>	<b>493430.0</b>	<b>3</b>	<b>493430.0</b>	<b>100%</b>

#### **4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Цаг хугацааны хязгаарлалтаас цалинг тогтоолт, олголтын байдлыг үзэж чадаагүй тул дараагийн аудитаар цалингийн зардлын зарцуулалтыг үзэх нь зүйтэй гэж үзлээ. Аудитаар өөр анхаарах татах асуудал гараагүй байна.

#### **5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

Аудитаар нийт 226.8 сая төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад 226.8 сая төгрөгийн алдааг залрууллаа.

*Залруулсан алдаа:*

- Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн нийт зардлыг 226.8 сая төгрөгөөр илүү тайлагнасан байсныг залрууллаа.

Энэ нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан төсөвт байгууллагын санхүүгийн тайлан гаргах заавар аргачлал, УСНББОУС 1 стандарт, толилуулга гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар зөрчил дутагдал илрээгүй байна.

#### **5.1 Төлбөрийн акт**

Төлбөрийн акт тогтоогдоогүй.

#### **5.2 Албан шаардлага**

Албан шаардлага өгөгдөөгүй.

#### **5.3 Зөвлөмж**

Аудитын дүнгээр нийт 1,484.6 сая төгрөгийн зөвлөмж өгөгдлөө.

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

### **1. Нягтлан бодох бүртгэл хөтлөлттэй холбоотой асуудал**

#### **1.1.Илрүүлэлт:**

Худалдан авсан бараа, ажил үйлчилгээнд төлсөн бүгд 239.8 сая төгрөгийн гүйлгээг тооцооны данс дамжуулахгүйгээр шууд зардлаар бүртгэж тайлагнасан.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3.1, 14.3.2, 14.3.3, 14.4.1,14.4.5, 14.4.6 дахь заалтууд, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлангийн аргачлал, зааврыг хэрэгжүүлээгүй байна.

#### **1.2. Өгсөн зөвлөмж:**

Худалдан авсан бараа, ажил үйлчилгээнд төлсөн зардлыг тооцооны дансаар дамжуулан бүртгэж тайлагнах, зөрчлийг давтан гаргахгүй байх.

---

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

## **1.2.Илрүүлэлт:**

Цалингийн зардал буюу унаа хоолны хөнгөлөлтийн зардлаас хоолны зардалд 36.9 сая төгрөгийг гүйлгэн зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 41 дүгээр зүйлийн 41.2.2-т "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах", 41.2.3-т "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж тайлагнах", Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан "Зардлын эдийн засгийн ангилал"-тай нийцэхгүй байна.

### **1.2. Өгсөн зөвлөмж:**

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3 дахь заалт, Сангийн сайдын 2023 оны 211 дүгээр тушаалаар баталсан журмыг мөрдөж ажиллах.

## **2. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал**

### **2.1 Илрүүлэлт:**

Нэгдсэн эмнэлэг нь тайлант онд 15446.3 сая төгрөгийн зарлага санхүүжилтээр ажиллаж, зарлагын 68.0 хувийг буюу 10,492.2 сая төгрөгийг цалин, нийгмийн даатгалын шитгэлийн зардалд зарцуулсан байна. Тайлант онд 32 эмч, эмнэлгийн ажилтан тэтгэвэрт гарч, 24 орон тоонд шинээр эмч, ажилтан авсан ба 11 дүгээр сарын 01-ний өдрөөс "Өлгий-Сансар" орон нутгийн өмчит эмнэлгийн 19 эмч, ажилтныг шилжүүлэн авснаар орон тоо нэмэгдэж оны эцэст нийгмийн даатгалын шимтгэл, хувь хүний орлогын албан татвар, үйлдвэрчний эвлэлийн татварт нийт 461.1 сая төгрөгийн өртэй гарсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.3-т "батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох", 41 дүгээр зүйлийн 41.2.2-т "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах", 41.2.3-т "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж тайлагнах" гэснийг зөрчсөн байна.

### **1.2. Өгсөн зөвлөмж:**

Нэгдсэн эмнэлгийн орон тооны хязгаарыг баримталж ажиллах, зайлшгүй шаардлагатайгаас бусад тохиолдолд тэтгэвэрт гарсан орон тоонд шинээр хүн ажиллуулахгүй байх, төсвийг үр ашигтай удирдаж, өр үүсгэхгүй ажиллах;

### **2.2 Илрүүлэлт:**

Тайлант онд худалдаж авсан бараа, үйлчилгээний зардалтай холбоотой байгууллагуудад төлөх 1,239.8 сая төгрөгийн өртэй гарсан байна.Үүнээс санхүүжилтийн авлага болох 595,2 сая төгрөгийг хасч тооцоход, бодитоор 644.6 сая төгрөгийн өрийг үүсгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэснийг зөрчсөн байна.

**1.2. Өгсөн зөвлөмж:**

Төсвийг үр ашигтай, зүй зохистой удирдаж, өрийг барагдуулах, өр үүсгэхгүй ажиллах;

**2.3 Илрүүлэлт:**

Тайлант онд тендер гүйцэтгэгчээр шалгараагүй компаниас нийт 102.1 сая төгрөгийн эмийг худалдан авч, үйл ажиллагаандаа зарцуулсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1-д “Энэ хуульд өөрөөр заагаагүй бол захиалагч бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад нээлттэй тендер шалгаруулалтын аргыг хэрэглэнэ”, 37 дугаар зүйлийн 37.1-д “нэгдүгээр үе шатанд худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага захиалагчийн худалдан авах бараа, үйлчилгээний хэрэгцээ шаардлагыг хангах бараа нийлүүлэгч, үйлчилгээ үзүүлэгчийг сонгон шалгаруулж, шалгарсан оролцогчтой ерөнхий гэрээ байгуулан, цахим дэглүүрт бүртгэх”, 37.1.2-т “хоёрдугаар үе шатанд захиалагч бараа, үйлчилгээг үнийн санал дуудаж цахим дэглүүрээс худалдан авах, 39 дүгээр зүйлийн 39.1-д “Захиалагч, шалгарсан оролцогчийн хооронд байгуулах бараа, ажил, үйлчилгээ худалдан авах гэрээ /цаашид “худалдан авах гэрээ” гэх/-ний гол нөхцөл нь тендер шалгаруулалтын баримт бичиг болон шалгарсан оролцогчийн ирүүлсэн тендер байна” гэснийг зөрчсөн байна.

**2.1. Өгсөн зөвлөмж:**

Тендер гүйцэтгэгчээр шалгараагүй компаниас бараа ажил үйлчилгээ худалдан авахгүй байх, холбогдох хууль тогтоомжийг мөрдөж ажиллах;

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2024 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн дотор Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн нийт зардлыг 226,754.3 мянган төгрөгөөр илүү тайлагнасан.	1	226,754.3	0	0	1	226,754.3	1	226,754.3				
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>226,754.3</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>1</b>	<b>226,754.3</b>	<b>1</b>	<b>226,754.3</b>				

/мянган төгрөгөөр/

Аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Бараа, ажил үйлчилгээнд төлсөн 239.8 сая төгрөгийн гүйлгээг шууд зардлаар бүртгэж тайлагнасан.	1	239,881.2					1	239,881.2				
Цалингийн зардлаас хоолны зардалд 36.9 сая төгрөгийг гүйлгэн зарцуулсан.	1	36,939.0					1	36,939.0				
Цалин, НДШ-ийн зардлын 461.1 сая төгрөгийн өртэй гарсан.	1	461,100.2					1	461,100.2				
Бараа, үйлчилгээний зардалтай холбоотой байгууллагуудад төлөх 644.6 сая төгрөгийн өртэй гарсан.	1	644,603.6					1	644,603.6				
Тайлант онд 102.1 сая төгрөгийн эмийг тендер шалгаруулалтг үйгээр худалдан авсан.	1	102,123.9					1	102,123.9				
<b>Дүн</b>	<b>5</b>	<b>1,484,647.9</b>					<b>5</b>	<b>1,484,647.9</b>				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
<b>Дүн</b>								